



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/61

Хатан суудал

Отроос ирж байгаа малчин
өрхүүдийг хүлээн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”-ын 2.6, Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/380 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулж, хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Отроос ирэх малчдын дамжин өнгөрөх маршрутыг гаргаж холбоо мэдээлэл, хяналтыг сайжруулж ажиллахыг ажлын хэсэг (Ж.Энхбат)-т үүрэг болгосугай.

3. Отроос ирж байгаа малчдын малд бүрэн үзлэг хийж, ариутгал халдваргүйжүүлэлтийг заавар журмын дагуу хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгүүдэд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642201043